

МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН САЙД,
ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2014 оны 04 дугаар
сарын 15 ны өдөр

Дугаар А/83 А/ИИ

Улаанбаатар хот

Цалин, нэмэгдэл тогтоох, хөнгөлөлт
эдлүүлэх ажилласан жилд оруулж
тооцох тухай

Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан шалтгаанаар 1990-1995 оны хооронд ажил хөдөлмөр эрхлээгүй буюу эрхлэх боломжгүй байсан хугацааг ажилласнаар нөхөн тооцуулсан иргэд хөдөлмөрийн харилцаанд шинээр орсноос үүсч буй зарим асуудлыг Хөдөлмөрийн болон Төрийн албаны тухай хуулийн холбогдох зүйл, заалтын хүрээнд зохицуулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Даатгуулагчийн ажилласнаар нөхөн тооцуулсан 1990-1995 оны хооронд дахь хугацааг нийт ажилласан болон төрийн албанд ажилласан хугацаанд оруулж, тухайн ажилтны үндсэн цалин, нэмэгдлийн хэмжээг тогтоох, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны ээлжийн амралтын хоногийг тооцоход харгалзан үзсүгэй.

2. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөрийн яамны Хөдөлмөрийн харилцааны бодлого, зохицуулалтын газар /Б. Алимаа/, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Л. Мөнхзул/-т даалгасугай.

3. Энэхүү тушаалыг 2014 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдсүгэй.

